

ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
САНХҮҮ, АЖАХУЙН АЛБАНЫ
ДАРГА ЦАГДААГИЙН ХУРАНДАА



ЖЭРДЭНЭБОЛД

ХУДАЛДАХ-ХУДАЛДАН АВАХ ГЭРЭЭ

(Тусгай зориулалтын хэрэгсэл худалдан авах тухай)

БАТЛАВ:

"АРИУН ТОТУ"
ХХК-НИЙ ДЭД ЗАХИРАЛ

П.Батбилэг
Ч.ТҮВШИНЖАРГАЛ

2018 оны 06 дугаар сарын 18-ны өдөр

Улаанбаатар хот

№ 57

НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ:

Энэхүү гэрээг нэг талаас Цагдаагийн ерөнхий газар (цаашид "Худалдан авагч" гэх), нөгөө талаас "Ариун тоту" ХХК-ийг төлөөлж менежер П.Батбилэг (цаашид "Худалдагч" гэх), нар (цаашид хамтад нь "Талууд" гэх) Монгол Улсын Иргэний хуулийн холбогдох заалтуудыг үндэслэн дор дурьдсан нөхцөлүүдийг харилцан тохиролцож байгуулав.

1. ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ:

1.1. Энэ гэрээний дагуу Худалдагч нь цахилгаан үйдлээр цохигч (цаашид "Бараа" гэх)-ийг гэрээнд заасан хугацаанд Худалдан авагчид хүлээлгэн өгөх, Худалдан авагч нь Барааг хүлээн авах, гэрээнд заасан нөхцөл журмаар үнийг төлнө.

2. ГЭРЭЭНИЙ ҮНЭ:

- 2.1. Энэхүү гэрээний нийт үнийн дүн нь 9,048,600 (есөн сая дөчин найман мянга зургаан зуу) төгрөг болно.
- 2.2. Гэрээний хавсралтад тодорхойлсон барааны гэрээний үнэ болох 9,048,600 (есөн сая дөчин найман мянга зургаан зуу) төгрөгийг барааг бүрэн хүлээлгэн өгч акт үйлдсэн үед Худалдагчийн Хаан банкны 5020610370 дугаар дансанд ажлын 5 хоногийн дотор шилжүүлнэ.

2.3. Барааг хүлээлгэн өгж акт үйлднэ. Барааг Худалдан авагчид шилжүүлэхтэй холбоотой зардлыг Худалдагч бүрэн хариуцна.

3. ХУДАЛДАН АВАГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ:

- 3.1. Худалдагчаас гэрээний дагуу хүлээсэн үүргээ зохих ёсоор, бүрэн дүүрэн биелүүлэхийг шаардах.
- 3.2. Барааны чанар, техникийн үзүүлэлтийн талаар гомдлын шаардлага гаргах. Гэрээний хавсралтад заасан чанар, бүрдэл дутуу Барааг шаардлага хангасан өөр бараагаар солиулах эрхтэй.
- 3.3. Худалдан авагч нь гэрээний 2.2-т заасан хугацаанд техникийн гэрчилгээ, бусад дагалдах бичиг баримтыг үндэслэн Барааг хүлээн авах үүрэгтэй ба хүлээн авах комисс томилж, Хүлээлцэх актанд гарын үсэг зуран хүлээн авна.
- 3.4. Худалдан авагч нь гэрээний 2.2 болон 2.3-т заасан хугацаанд гэрээний үнийг Худалдагчийн харилцах дансанд шилжүүлэх үүргийг хүлээнэ.

4. ХУДАЛДАГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ:

- 4.1. Худалдан авагчийг гэрээний дагуу хүлээсэн үүргээ биелүүлэхийг шаардах,
- 4.2. Гэрээний хавсралтад тодорхойлсон чанар бүрдэл бүхий чанарын шаардлага хангасан баглаа боодол бүхий Барааг гэрээнд заасан хугацаанд Худалдан авагчид хүлээлгэн өгөх үүргийг хүлээнэ.